



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 31 өдөр

Дугаар 6/21

Ховд

М.Нансалмаад ажил хавсран гүйцэтгүүлэх тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 50 дугаар зүйлийн 50.2, 50.3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийтийн аж ахуй үйлчилгээний "Шим ус" орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга Т.Баатарзориг Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн хуулийн дагуу чөлөөлөгдөх хүсэлтээ ирүүлж ажлаас чөлөөлөгдсөн тул тус газрын даргын ажил үүргийг 2020 оны 08 дугаар сарын 03-ний өдрөөс эхлэн Ерөнхий инженер М.Нансалмаад хавсруулсугай.


2. М.Нансалмаад ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хөлсийг үндсэн цалингийн 40 хувиар тооцон сар бүр олгохыг нягтлан бодогч /Ч.Даваадорж/-д зөвшөөрсүгэй.

3. Нийтийн аж ахуй үйлчилгээний "Шим ус" орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын даргын чиг үүргийг хэрэгжүүлж, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох дүрэм журмыг мөрдөж ажиллахыг /М.Нансалмаа/-д зөвлөсүгэй.

4. Ажил хүлээлцүүлэх ажлын хэсгийг хавсралтаар баталж, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/-д даалгасугай.


ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



02 01334

Аймгийн Засаг даргын 2020 оны
07 дугаар сарын 31-ний өдрийн
Б/21 дүгээр захирамжийн хавсралт



АЖИЛ ХҮЛЭЭЛЦЭХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ажлын хэсгийн ахлагч: Д.Энхболд - Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
- Гишүүд: О. Киват - Нийтийн аж ахуй үйлчилгээний "Шим ус" орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын цэвэрлэх байгууламжийн техникч
- Ч.Даваадорж - Нийтийн аж ахуй үйлчилгээний "Шим ус" орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын нягтлан бодогч
- Б.Оюунзаяа - Нийтийн аж ахуй үйлчилгээний "Шим ус" орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын нярав
- Нарийн бичгийн дарга: Л.Батгэрэл - Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

-оОо-